



ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРЫН СТАТИСТИКИЙН МЭДЭЭ

2025 оны I улирал

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ
БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН
СУДАЛГАА, СТАНДАРТ, СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

2025 оны 04 сарын 14
Улаанбаатар хот

НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР

Үзүүлэлт

Тодорхойлолт*

Тээсэн ачаа	Тодорхой хугацаанд, тодорхой зайд тээвэрлэсэн нийт ачааг илэрхийлнэ. Тээсэн ачаа нь дотроо олон төрлийн байдгаас салбаруудын онцлогоос шалтгаалан ачааг шинж чанараар нь тодорхой бүлэг, ангилалд хуваадаг. Тээсэн бүх төрлийн ачааг тус бүр хэмжих нэгжийг нь харгалзахгүйгээр тонноор илэрхийлнэ.
Ачаа эргэлт	Нэг тонн ачааг нэг км-ээс дээш зайд тээвэрлэсэн тээврийг хэмждэг нэгж юм. Ачаа эргэлт болон тээвэрлэсэн ачааны хэмжээг тээврийн төрөл тус бүр дээр ачааны төрлөөр тооцно. Ачаа эргэлтийг тн.км-ээр илэрхийлнэ.
Тээсэн зорчигч	Тодорхой хугацаанд тодорхой зайд тээвэрлэсэн нийт зорчигчдын тоог хэлнэ.
Зорчигч эргэлт	Нэг зорчигчийг нэг км-ээс дээш зайд тээвэрлэсэн тээврийг хэмждэг нэгж юм. Зорчигч эргэлтийг хүн.км-ээр илэрхийлнэ.
Шилжүүлсэн тн.км	Тээврээр гүйцэтгэсэн олон төрөл, хэлбэрийн ажил, үйлчилгээг тусгай коэффициентуудыг ашиглан нэг нэгжид буюу тонн километрт шилжүүлсэн үзүүлэлт юм. Энэ үзүүлэлт тээврийн төрөл тус бүрт харилцан адилгүй тооцогддог.
Тээврийн орлого	Тээврийн үйлчилгээ үзүүлсний төлбөр болгож авч байгаа өртгийн нийлбэр юм. Өөрөөр хэлбэр тээврийн байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнд буюу ачаа, зорчигч тээвэрлэлт, түүнтэй холбогдсон үйл ажиллагаанаас орсон орлого юм. Үүнийг тухайн оны үнээр тооцно.

*Тээврийн салбарт ашиглагддаг ойлголт, тодорхойлолт

ТАНИЛЦСАН:

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

С.БАТБОЛД

ХЯНАСАН:

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН ДАРГА

Г.БАТБАЯР

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН СУДАЛГАА, СТАНДАРТ, СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.МЯДАГМАА

БОЛОВСРУУЛСАН:

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН СУДАЛГАА, СТАНДАРТ, СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Ц.НЭМЭХЖАРГАЛ

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН СУДАЛГАА, СТАНДАРТ, СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Э.ЭНХЗААЯ

Энэхүү эмхэтгэлийг ҮСХ, яам, харьяа байгууллагуудын болон Зам, тээврийн салбарын мэдээллийн нэгдсэн платформ¹ бүртгэгдэж буй тоон үзүүлэлт, статистик мэдээллийг нэгтгэн гаргалаа.

¹ Зам, тээврийн салбарын статистик мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгох, салбар байгууллагуудын мэдээлэл солилцооны уялдаа холбоог бэхжүүлэх, мэдээллийг түргэн шуурхай олон нийтэд хүргэх зорилгоор платформыг 2022 оны 1 дүгээр сараас хөгжүүлж эхэлсэн.

АГУУЛГА

БҮЛЭГ 1. ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРЫН СТАТИСТИКИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ	5
1.1. АЧАА ТЭЭВЭР	6
1.2. ЗОРЧИГЧ ТЭЭВЭР	7
БҮЛЭГ 2. АВТОТЭЭВРИЙН САЛБАР	8
2.1. АВТОТЭЭВРИЙН АЧАА	8
2.1.1. АВТОТЭЭВРИЙН ЭКСПОРТЫН АЧАА, БООМТУУДААР.....	9
2.1.2. АВТОТЭЭВРИЙН ИМПОРТЫН АЧАА, БООМТУУДААР.....	10
2.1.3. АВТОТЭЭВРИЙН АЧААНЫ НЭР ТӨРӨЛ.....	11
2.1.4. АВТОТЭЭВРИЙН АЧАА ЭРГЭЛТ, БООМТУУДААР.....	12
2.2. АВТОТЭЭВРИЙН ЗОРЧИГЧ	12
2.3. АВТО ЗАМЫН БООМТУУДААР НЭВТЭРСЭН АЧААТАЙ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН БҮРТГЭЛ	14
БҮЛЭГ 3. ТӨМӨР ЗАМЫН САЛБАР	15
3.1. ТӨМӨР ЗАМЫН АЧАА	15
3.2. ТӨМӨР ЗАМЫН ЗОРЧИГЧ	18
БҮЛЭГ 4. ИРГЭНИЙ НИСЭХИЙН САЛБАР	19
4.1 АГААРЫН ТЭЭВРИЙН АЧАА	19
4.2. АГААРЫН ТЭЭВРИЙН ЗОРЧИГЧ	20
4.2.1. АГААРЫН ТЭЭВРИЙН ОЛОН УЛСЫН ЗОРЧИГЧ	21
4.2.2. АГААРЫН ТЭЭВРИЙН ОРОН НУТГИЙН ЗОРЧИГЧ	22
4.3. НИСЛЭГ ГҮЙЦЭТГЭЛ.....	23

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Зам, тээврийн салбарын статистикийн үндсэн үзүүлэлт.....	5
Хүснэгт 2. Автотээврийн ачаа тээвэр.....	8
Хүснэгт 3. Автотээврийн экспортын ачаа, боомтуудаар.....	9
Хүснэгт 4. Автотээврийн импортын ачаа, боомтуудаар.....	10
Хүснэгт 5. Автотээврийн ачааны нэр төрөл.....	11
Хүснэгт 6. Автотээврийн ачаа эргэлт.....	12
Хүснэгт 7. Автотээврийн зорчигч.....	12
Хүснэгт 8. Хот хоорондын нийтийн тээврийн зорчигч.....	13
Хүснэгт 9. Авто замын боомтуудаар гарсан ачаатай тээврийн хэрэгслийн бүртгэл.....	14
Хүснэгт 10. Төмөр замын ачаа тээвэр.....	15
Хүснэгт 11. Төмөр замын зорчигч тээвэр.....	18
Хүснэгт 12. Агаарын тээврийн ачаа.....	19
Хүснэгт 13. Агаарын тээврийн зорчигч.....	20
Хүснэгт 14. Агаарын тээврийн олон улсын зорчигч.....	21
Хүснэгт 15. Агаарын тээврийн орон нутгийн зорчигч.....	22
Хүснэгт 16. Нислэг гүйцэтгэл.....	23

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Нийт ачаа тээвэр.....	6
Зураг 2. Нийт экспорт.....	6
Зураг 3. Нийт импорт.....	6
Зураг 4. Нийт зорчигч тээвэр.....	7
Зураг 5. Олон улсад зорчигч.....	7
Зураг 6. Орон нутагт зорчигч.....	7
Зураг 7. Автотээврээр тээвэрлэсэн ачаа, тонн, сараар.....	8
Зураг 8. Автотээврийн ачааны экспорт, импортын эзлэх хувь.....	8
Зураг 9. Автотээврийн экспортын ачаа, тонн, боомтоор.....	9
Зураг 10. Автотээврийн импортын ачаа, тонн, боомтоор.....	10
Зураг 11. Экспортын ачааны нэр төрөл, тонн, сараар.....	11
Зураг 12. Экспортын нүүрсний хэмжээ, тонн, сараар.....	11
Зураг 13. Автотээврийн зорчигч.....	12
Зураг 14. Хилээр нэвтэрсэн тээврийн хэрэгсэл.....	14
Зураг 15. Төмөр замын ачаа	15
Зураг 16. Төмөр замын ачаа, байгууллагуудын эзлэх хувь.....	16
Зураг 17. Төмөр замын ачаа тээврийн төрөл.....	16
Зураг 18. Дотоодын ачаа, байгууллагуудын эзлэх хувь.....	16
Зураг 19. Хоногт тээвэрлэх ачааны дундаж жин, мян.тн, байгууллагаар.....	16
Зураг 20. Төмөр замаар тээвэрлэсэн ачааны хэмжээ, өдрөөр, 2025.01.01-2025.03.31.....	17
Зураг 21. Төмөр замын байгууллагуудын ачаа тээвэр, хоногоор.....	17
Зураг 22. Төмөр замын зорчигч тээвэр.....	18
Зураг 23. Төмөр замын зорчигч, хоногоор.....	18
Зураг 24. Агаараар тээвэрлэсэн ачаа болон шуудан.....	19
Зураг 25. Олон улс, орон нутгийн ачаа, шуудан.....	19
Зураг 26. Нийт ачаа, шуудан тээвэр, тонн, сараар.....	19
Зураг 27. Агаарын тээврээр зорчсон зорчигчдын тоо.....	20
Зураг 28. Агаарын тээврийн зорчигчдын тоо, сараар.....	20
Зураг 29. Олон улсын зорчигч тээвэр, чиглэлээр.....	21
Зураг 30. Олон улсын зорчигч, агаарын тээвэрлэгч байгууллагуудын эзлэх хувь.....	22
Зураг 31. Орон нутгийн зорчигч, чиглэлээр.....	22
Зураг 32. Орон нутгийн зорчигч, агаарын тээвэрлэгч байгууллагуудын эзлэх хувь.....	23
Зураг 33. Нислэг гүйцэтгэлийн мэдээ, сараар.....	23

БҮЛЭГ 1. ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРЫН СТАТИСТИКИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ²

Хүснэгт 1



№	Үзүүлэлт	Тээврийн төрөл	Хэмжих нэгж	2024 он		2025 он		Өсөлт бууралтын % 2025.I/2024.I
				3-р сар	I улирал	3-р сар	I улирал	
1	Тээвэрлэсэн ачаа	Автотээвэр	мян.тн	7,354.4	17,945.7	6,450.2	18,720.2	4.3%
		Төмөр зам	мян.тн	3,905.6	10,900.3	3,403.0	10301.3	-5.5%
		Агаарын тээвэр	мян.тн	0.8	2.2	0.7	2.0	-7.6%
		Нийт ачаа	мян.тн	11,260.7	28,848.2	9,853.9	29,023.5	0.6%
2	Дамжин өнгөрөх ачаа /транзит/	Төмөр зам	мян.тн	418.5	1,273.2	518.7	1,389.9	9.2%
3	Ачаа гаргалт /экспорт/	Төмөр зам	мян.тн	991.6	2,741.7	907.0	2,773.1	1.1%
		Автотээвэр	мян.тн	7,141.2	17,463.2	6,234.9	18,174.0	4.1%
		Нийт	мян.тн	8,132.8	20,205.0	7,142.0	20,947.1	3.7%
4	Ачаа оруулалт /импорт/	Төмөр зам	мян.тн	329.4	1,010.0	266.3	887.1	-12.2%
		Автотээвэр	мян.тн	213.2	482.4	215.3	546.2	13.2%
		Нийт	мян.тн	542.6	1,492.4	481.6	1,433.3	-4.0%
5	Дотоодод тээвэрлэсэн ачаа	Төмөр зам	мян.тн	2,166.0	5,875.4	1,710.9	5,251.2	-10.6%
		Агаарын тээвэр	мян.тн	0.8	2.2	0.7	2.0	-7.6%
		Нийт	мян.тн	2,166.8	5,877.6	1,711.6	5,253.2	-10.6%
6	Ачаа эргэлт	Автотээвэр	сая тн.км	1,118.8	2,909.3	964.7	2,969.1	2.1%
		Төмөр зам	сая тн.км	1,862.6	5,249.4	1,807.6	5,202.0	-0.9%
		Агаарын тээвэр	сая.тн.км	3.0	7.3	3.8	9.3	27.1%
		Нийт ачаа эргэлт	сая тн.км	2,984.4	8,166.0	2,776.1	8,180.4	0.2%
7	Зорчигчдын тоо	Автотээвэр	мян.хүн	12,922.6	33,883.4	13,850.9	36,649.3	8.2%
		Төмөр зам	мян.хүн	141.8	435.2	138.0	399.2	-8.3%
		Агаарын тээвэр	мян.хүн	127.6	412.0	148.1	479.3	16.4%
		Нийт зорчигч	мян.хүн	13,191.9	34,730.6	14,137.0	37,527.9	8.1%
8	Олон улсад зорчигчдын тоо	Автотээвэр	мян.хүн	52.6	160.2	26.3	116.4	-27.4%
		Төмөр зам	мян.хүн	1.9	5.6	2.1	7.2	27.2%
		Агаарын тээвэр	мян.хүн	95.4	314.8	114.3	380.8	21.0%
		Нийт ОУ зорчигч	мян.хүн	150.0	480.6	142.6	504.3	4.9%
9	Орон нутагт зорчигчдын тоо	Автотээвэр	мян.хүн	100.2	357.5	124.3	378.7	6.0%
		Төмөр зам	мян.хүн	139.9	429.6	135.9	392.1	-8.7%
		Агаарын тээвэр	мян.хүн	32.1	97.1	33.9	98.5	1.4%
		Нийт ОН зорчигч	мян.хүн	272.2	884.2	294.0	869.3	-1.7%
10	Нийслэл дэх нийтийн тээврийн зорчигчдын тоо	Автотээвэр	мян.хүн	12,769.7	33,365.7	13,700.3	36,154.2	8.4%
11	Зорчигч эргэлт	Автотээвэр	сая хүн.км	168.6	512.4	185.4	541.3	5.6%
		Төмөр зам	сая хүн.км	57.6	172.5	56.5	167.4	-3.0%
		Агаарын тээвэр	сая хүн.км	281.2	1,008.5	340.4	1,261.4	25.1%
		Нийт	сая хүн.км	507.4	1,693.4	582.3	1,970.1	16.3%
12	Агаарын тээврийн нислэгийн тоо	Олон улсын хөөрөлт, буултын тоо	ш	795.0	2,432.0	877	2,800	15.1%
		Орон нутгийн хөөрөлт, буултын тоо	ш	599.0	1,784.0	742	2,054	15.1%
		Олон улсын өнгөрөлтийн нислэгийн тоо	ш	5,080.0	14,772.0	6,332	18,251	23.6%
13	Авто замын боомтуудаар гарсан ачаатай тээврийн хэрэгсэл		ш	72,373.0	168,831.0	51,049.0	168,074.0	-0.4%
14	Авто замын боомтуудаар орсон ачаатай тээврийн хэрэгсэл		ш	8,926.0	20,886.0	10,286.0	27,827.0	33.2%

² Зам, тээврийн салбарын 2025 оны I улирлын статистикийн мэдээг 2025 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр гаргав.

1.1. АЧАА ТЭЭВЭР


Улсын хэмжээнд бүх төрлийн тээврээр 2025 оны 3 дугаар сард 9.9 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны 3 дугаар сартай харьцуулахад 12.5%-аар буурсан байна. Харин 2025 оны I улиралд 29 сая тонн ачаа тээсэн нь өмнөх оны мөн үеэс 0.6%-аар өссөн байна.

- Автотээврээр 2025 оны нэгдүгээр улирлын байдлаар нийт 18.7 сая тонн ачаа тээсэн нь өмнөх оны мөн үеэс 4.3%-аар, экспортын ачаа 18.2 сая тонн болж өмнөх оны мөн үеэс 4.1%-аар, импортын ачаа 546.2 мянган тонн болж 13.2%-аар өмнөх оны мөн үеэс тус тус өссөн байна.
- Төмөр замаар 2025 оны нэгдүгээр улиралд нийт 10.3 сая тонн ачаа тээвэрлэж өмнөх оны мөн үеэс 5.5%-аар, дотоодын ачаа 5.3 сая тонн болж 10.6%-аар, импортын ачаа 887.1 мянган тонн болж өмнөх оны мөн үеэс 12.2%-аар тус тус буурсан бол дамжин өнгөрсөн ачаа 1.4 сая тонн болж 9.2%-аар, экспортын ачаа 2.8 сая тонн болж өмнөх оны нэгдүгээр улиралтай харьцуулахад 1.1%-аар тус тус өссөн байна.
- Агаарын тээврээр 2025 оны нэгдүгээр улиралд 2,026.0 тонн ачаа болон шуудан тээвэрлэж өмнөх оны I улирлаас 7.6%-аар буурсан байна. Үүнээс ачаа 1,974.4 тонн тээвэрлэсэн нь 7.4%-аар, шуудан 51.6 тонн тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 12.2%-аар тус тус буурсан байна



3 дугаар сард экспортоор 7.1 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны 3 дугаар сартай харьцуулахад 12.2%-аар буурсан байна. Харин 2025 оны нэгдүгээр улиралд экспортын хэмжээ 20.9 сая тонн болж өмнөх оны мөн үеэс 3.7%-аар өссөн байна. Үүнээс төмөр замаар 2.8 сая тонн тээвэрлэсэн нь 1.1%-аар, автотээврээр 18.2 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 4.1%-аар тус тус өссөн байна. Нийт экспортын дүнд автотээвэр 87%-ийг, төмөр зам 13%-ийг эзэлж байна. /Зураг 2/

Импортын ачаа 2025 оны 3 дугаар сард нийт 481.6 мянган тонн болж өмнөх оны 3 дугаар сартай харьцуулахад 11.2%-аар буурсан. Харин улирлын дүнгээр нийт 1.4 сая тонн ачаа импортолсон нь өмнөх оны мөн үеэс 4%-аар буурчээ. Үүнээс төмөр замаар 887.1 мянган тонн ачаа импортолсон нь 12.2%-аар буурсан бол автотээврээр 546.2 мянган тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 13.2%-аар өссөн байна. Импортын тээврийн 62%-ийг төмөр замаар, 38%-ийг автотээврээр тээсэн байна.




1.2. ЗОРЧИГЧ ТЭЭВЭР


Бүх төрлийн тээврээр 2025 оны 3 дугаар сард 14.1 сая зорчигч (давхардсан тоогоор) зорчсон нь өмнөх оны 3 дугаар сартай харьцуулахад 7.2%-аар өссөн. 2025 оны нэгдүгээр улиралд 37.5 сая зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 8.1%-аар өссөн үзүүлэлттэй байна.

- Автотээврээр 2025 оны нэгдүгээр улиралд нийт 36.6 сая зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 8.2%-аар өсчээ. Үүнээс нийслэлийн нийтийн тээврээр 36.2 сая зорчигч (+8.4%), орон нутагт 378.7 мянган зорчигч (+6%), олон улсад 116.4 мянган зорчигч (-27.4%) зорчжээ. /Доорх графикт нийслэлийн нийтийн тээврийн зорчигчийг хассан болно./
- Төмөр замаар 2025 оны нэгдүгээр улиралд нийт 399.2 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 8.3%-аар буурсан байна. Үүнээс олон улсад 7.2 мянган зорчигч зорчсон нь 27.2%-аар өссөн бол орон нутагт 392.1 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 8.7%-аар буурсан байна.
- Агаарын тээврээр 2025 оны нэгдүгээр улиралд нийт 479.3 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 16.4%-аар өссөн бол үүнээс олон улсад 380.8 мянган зорчигч зорчсон нь 21%-аар, орон нутагт 98.5 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 1.4%-аар тус тус нэмэгдсэн байна.

Зураг 4. Нийт зорчигч тээвэр, мян. хүн




Зураг 5. Олон улсын зорчигч



2025 оны нэгдүгээр улиралд олон улсад нийт 504.3 мянган зорчигч (+4.9%) зорчсон бөгөөд үүнээс агаарын тээврээр 380.8 мянган зорчигч (+21%), автотээврээр 116.4 мянган зорчигч (-27.4%), төмөр замаар 7.2 мянган зорчигч (+27.2%) тус тус зорчсон байна. Олон улсад зорчигчдын нийт дүнд агаарын тээвэр 76%, автотээвэр 23%, төмөр зам 1%-ийг эзэлж байна. /Зураг 5/

2025 оны нэгдүгээр улиралд орон нутагт нийт 869.3 мянган зорчигч (-1.7%) зорчсон бөгөөд үүнээс автотээврээр 378.7 мянган зорчигч (+6%), төмөр замаар 392.1 мянган зорчигч (-8.7%), агаарын тээврээр 98.5 мянган зорчигч (+1.4%) тус тус зорчоод байна. Орон нутагт зорчигчдын нийт дүнд агаарын тээвэр 11%, автотээвэр 44%, төмөр зам 45%-ийг эзэлж байна. /Зураг 6/

Зураг 6. Орон нутагт зорчигч



БҮЛЭГ 2. АВТОТЭЭВРИЙН САЛБАР

2.1. АВТОТЭЭВРИЙН АЧАА³

2025 оны нэгдүгээр улиралд авто замаар нийт 18.7 сая тонн ачаа тээвэрлэснээс 18.2 сая тонн ачаа экспортолсон байна.


Хүснэгт 2

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2024 он		2025 он		Өсөлт бууралтын % 2025.I/2024.I
		3 дугаар сар	I улирал	3 дугаар сар	I улирал	
Нийт ачаа	тонн	7,354,411.7	17,945,686.2	6,450,195.0	18,720,185.0	4.3%
Импорт	тонн	213,191.9	482,442.3	215,262.0	546,218.0	13.2%
Экспорт	тонн	7,141,219.8	17,463,244.0	6,234,933.0	18,173,967.0	4.1%
Ачаа эргэлт	тн.км	1,118,816,565.6	2,909,304,483.1	964,739,733.0	2,969,088,122.0	2.1%

2025 оны 3 дугаар сард автотээвэрээр 6.5 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны 3 дугаар сартай харьцуулахад 12.3%-аар буурсан байна. Үүнээс экспортод 6.2 сая тонн ачаа тээвэрлэсэн нь 12.7%-аар буурсан бол импортоор 215.3 мянган тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны 3 дугаар сараас 1.0%-аар өссөн үзүүлэлттэй байна. Харин ачаа эргэлт 3 дугаар сард 1 тэрбум тонн км болсон нь өмнөх оны 3 дугаар сараас 13.8%-аар буурсан байна.

Сар бүр тээвэрлэсэн нийт ачааны хэмжээг зураг 7-д харуулав.


Зураг 7. Автотээвэрээр тээвэрлэсэн ачаа, тонн, сараар



Нэгдүгээр улирлын байдлаар автотээвэрээр нийт 18.7 сая тонн ачаа тээсэн нь өмнөх оны нэгдүгээр улирлаас 4.3%-аар, экспортын ачаа 18.2 сая тонн болж өмнөх оны мөн үеэс 4.1%-аар, импортын ачаа 546.2 мянган тонн болж өмнөх оны мөн үеэс 13.2%-аар тус тус өссөн байна. Ачаа эргэлт 2.9 тэрбум тонн км болж өмнөх оны мөн үеэс 2.1%-аар өссөн байна.

2025 оны нэгдүгээр улирлын байдлаар нийт ачаа тээврийн 18.2 сая тонн буюу 97%-ийг экспортын ачаа, 546.2 мянган тонн буюу 3%-ийг импортын ачаа эзэлж байна. Экспортын ачаанд уул уурхайн бүтээгдэхүүний ачаа дийлэнх хувийг эзэлж байгаа бөгөөд Гашуунсухайт боомтоор экспортын ачааны 52%-ийг нэвтрүүлсэн байна. Харин импортын ачааны 79%-ийг Замын-Үүд боомтоор оруулж ирсэн ачаа эзэлж байна. /Зураг 8/

Зураг 8. Автотээврийн ачааны экспорт, импортын эзлэх хувь



³ "Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын статистикийн мэдээ

2.1.1. АВТОТЭЭВРИЙН ЭКСПОРТЫН АЧАА, БООМТУУДААР

Хүснэгт 3

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2024 он		2025 он		Өсөлт бууралтын % 2025.I/2024.I
			3 дугаар сар	I улирал	3 дугаар сар	I улирал	
1	Нийт ачаа тээвэр	тонн	7,354,411.7	17,945,686.2	6,450,195.0	18,720,185.0	4.3%
2	Экспорт-боомтуудаар	тонн	7,141,219.8	17,463,244.0	6,234,933.0	18,173,967.0	4.1%
3	ОХУ-руу	тонн	3,367.0	12,023.0	3,366.0	13,418.0	11.6%
4	Алтанбулаг	тонн	3,367.0	12,023.0	3,366.0	13,418.0	11.6%
5	Боршоо	тонн	0.0	0.0	0.0	0.0	-
6	Цагаан нуур	тонн	0.0	0.0	0.0	0.0	-
7	БНХАУ-руу	тонн	7,137,852.8	17,451,221.0	5,604,036.0	18,160,549.0	4.1%
8	Бичигт	тонн	157,743.0	478,563.0	660,451.0	1,773,597.0	270.6%
9	Баянхошуу	тонн	40,957.0	126,649.6	36,460.0	109,038.0	-13.9%
10	Бургастай	тонн	53,038.0	139,746.0	0.0	29,742.0	-78.7%
11	Булган	тонн	306,039.0	674,555.0	305,567.0	685,532.0	1.6%
12	Гашуунсухайт	тонн	3,480,574.1	9,565,267.2	2,911,927.0	9,427,285.0	-1.4%
13	Замын-Үүд	тонн	88,859.0	219,532.0	50,016.0	160,200.0	-27.0%
14	Ханги	тонн	745,380.8	1,766,511.3	385,997.0	1,288,066.0	-27.1%
15	Хавирга	тонн	9,452.9	9,452.9	224.0	29,743.0	214.6%
16	Шивээ хүрэн	тонн	2,255,809.0	4,470,944.0	1,253,394.0	4,657,346.0	4.2%
17	Сүмбэр	тонн	0.0	0.0	0.0	0.0	-

Зураг 9. Автотээврийн экспортын ачаа, тонн, боомтоор



ОХУ-тай хиллэдэг Алтанбулаг боомтоор 2025 оны 3 сард 3.4 мянган тонн ачаа, харин нэгдүгээр улирлын байдлаар 13.4 мянган тонн ачаа гарсан нь өмнөх оны мөн үеэс 11.6%-аар өссөн байна.

БНХАУ-тай хиллэдэг боомтуудаар 3 сард 5.6 сая тонн ачаа, харин нэгдүгээр улирлын байдлаар 18.2 сая тонн ачаа гарсан нь 4.1%-аар өссөн байна. Үүнээс хамгийн их ачааг Гашуунсухайт боомтоор нэвтрүүлсэн бөгөөд 9.4 сая тонн (-1.4%) ачаа тээвэрлэсэн нь нийт экспортын 52%-ийг дангаараа бүрдүүлж байна. Шивээхүрэн боомтоор 4.7 сая тонн (+4.2%), Бичигт боомтоор 1.8 сая тонн (+270.6%), Ханги боомтоор 1.3 сая тонн (-27.1%), Булган боомтоор 685.5 мянган тонн (+1.6%), Замын-Үүд боомтоор 160.2 мянган тонн (-27%), Баянхошуу боомтоор 109 мянган тонн (-13.9%), Бургастай боомтоор 29.7 мянган тонн (-78.7%), Хавирга боомтоор 19.7 мянган тонн (+214.6%) ачаа тус тус экспортод гарсан байна. /Зураг 9/

2.1.2 АВТОТЭЭВРИЙН ИМПОРТЫН АЧАА, БООМТУУДААР

Хүснэгт 4

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2024 он		2025 он		Өсөлт бууралтын % 2025.I/2024.I
			3 дугаар сар	I улирал	3 дугаар сар	I улирал	
1	Нийт ачаа тээвэр	тонн	7,354,411.7	17,945,686.2	6,450,195.0	18,720,185.0	4.3%
2	Импорт–боомтуудаар	тонн	213,191.9	482,442.3	215,262.0	546,218.0	13.2%
3	ОХУ-аас	тонн	39,348.9	98,905.9	16,191.0	53,607.0	-45.8%
4	Алтанбулаг	тонн	18,916.3	42,263.5	12,207.0	37,691.0	-10.8%
5	Боршоо	тонн	5,172.3	14,434.4	1,279.0	7,410.0	-48.7%
6	Цагаан нуур	тонн	15,260.3	42,208.0	2,705.0	10,808.0	-74.4%
7	БНХАУ-аас	тонн	173,843.0	383,536.4	199,071.0	492,611.0	28.4%
8	Бичигт	тонн	508.0	1,593.0	0.0	0.0	-100.0%
9	Баянхошуу	тонн	0.0	0.0	0.0	0.0	-
10	Бургастай	тонн	0.0	0.0	0.0	0.0	-
11	Булган	тонн	0.0	0.0	0.0	0.0	-
12	Гашуунсухайт	тонн	6,960.0	21,560.0	23,080.0	42,960.0	99.3%
13	Замын-Үүд	тонн	153,179.0	334,117.5	168,736.0	430,442.0	28.8%
14	Ханги	тонн	1,000.0	3,500.0	920.0	2,145.0	-38.7%
15	Хавирга	тонн	2,436.0	4,365.9	375.0	3,384.0	-22.5%
16	Шивээ хүрэн	тонн	9,760.0	18,400.0	5,960.0	13,680.0	-25.7%

Автотээврээр 2025 оны 3 дугаар сард импортоор 215.3 мянган тонн ачаа тээвэрлэсэн нь 16.2 мянган тонныг ОХУ-аас, 199.1 мянган тонн ачааг БНХАУ-аас оруулж ирсэн байна.

Харин нэгдүгээр улирлын байдлаар импортын ачаа 546.2 мянган тонн байснаас 53.6 мянган тонныг ОХУ-аас оруулж ирсэн нь өмнөх оны мөн үеэс 45.8%-аар буурсан бол 492.6 мянган тонн ачааг БНХАУ-аас оруулж ирсэн нь өмнөх оны мөн үеэс 28.4%-аар өссөн байна.

Зураг 10. Автотээврийн импортын ачаа, тонн, боомтоор

2025 оны нэгдүгээр улиралд ОХУ-аас 53.6 мянган тонн ачаа оруулж ирснээс Алтанбулаг боомтоор 37.6 мянган тонн (-10.8%), Цагааннуур боомтоор 10.8 мянган тонн (-74.4%), Боршоо боомтоор 7.4 мянган тонн (-48.7%) ачаа тус тус орж иржээ.

БНХАУ-аас 492.6 мянган тонн ачаа оруулж ирснээс Замын-Үүд боомтоор 430.4 мянган тонн ачаа (+28.8%), Гашуунсухайт боомтоор 42.9 мянган тонн ачаа (+99.3%), Шивээхүрэн боомтоор 13.7 мянган тонн ачаа (-25.7%), Хавирга боомтоор 3.4 тонн ачаа (-22.5%), Ханги боомтоор 2.1 мянган тонн ачаа (-38.7%) оруулсан байна.

Импортын ачааны 77%-ийг БНХАУ-аас, 23%-ийг ОХУ-аас оруулж ирсэн. **Нийт импортын ачааны 79%-ийг Замын-Үүд боомтоор оруулж байна.** /Зураг 10/



■ 2025 оны эхний улирал ■ 2024 оны эхний улирал

2.1.3. АВТОТЭЭВРИЙН АЧААНЫ НЭР ТӨРӨЛ


Хүснэгт 5

Ачааны нэр төрлөөр	Хэмжих нэгж	2024 он		2025 он		Өсөлт бууралтын % 2025.I/2024.I
		3 дугаар сар	I улирал	3 дугаар сар	I улирал	
Нүүрс	тонн	6,936,140.2	16,894,083.4	6,027,350.1	17,578,168.9	4.0%
Газрын тос	тонн	40,956.6	126,649.2	37,235.2	109,038.5	-13.9%
Зэсийн баяжмал	тонн	63,622.7	215,625.7	127,723.2	302,274.8	40.2%
Төмрийн хүдэр	тонн	80,202.6	171,670.3	14,483.0	54,744.5	-68.1%
Жонш	тонн	4,977.6	21,681.5	14,924.3	88,951.3	310.3%
Цайр	тонн	2,699.0	2,699.0	0.0	0.0	-100.0%
Бусад	тонн	12,621.1	30,834.9	13,217.2	40,789.0	32.3%

Авто замын боомтуудаар гарсан ачааг нэр төрлөөр авч үзвэл нүүрс 3 дугаар сард 6 сая тонн (-13.1%), зэсийн баяжмал 127.7 мянган тонн (+100.8%), газрын тос 37.2 мянган тонн (-9.1%), төмрийн хүдэр 14.5 мянган тонн (-81.9%), жонш 14.9 мянган тонн (+199.8%), бусад ачаа 13.2 мянган тонн ачаа (+4.7%) гаргасан байна.


2025 оны нэгдүгээр улирлын байдлаар нийт нүүрс 17.6 сая тонн (+4.0%), зэсийн баяжмал 302.3 мянган тонн (+40.2%), төмрийн хүдэр 54.7 мянган тонн (-68.1%), газрын тос 109 мянган тонн (-13.9%), жонш 88.9 мянган тонн (+310.3%), бусад 40.8 мянган тонн ачаа (+32.3%) тус тус экспортод тээвэрлэжээ. /Зураг 11/

Зураг 11. Экспортын ачааны нэр төрөл, тонн, сараар



Авто замын боомтуудаар экспортод гарсан нүүрсний хэмжээг доорх графикт харуулав. 2025 оны 3 дугаар сард 6 сая тонн гарсан нь өмнөх оны 3 дугаар сараас 13.1%-аар буурсан бол нэгдүгээр улирлын байдлаар 17.6 сая тонн нүүрс гарсан нь өмнөх оны нэгдүгээр улиралтай харьцуулахад 4%-аар өссөн байна. /Зураг 12/

Зураг 12. Экспортын нүүрсний хэмжээ, тонн, сараар



2.1.4. АВТОТЭЭВРИЙН АЧАА ЭРГЭЛТ, БООМТУУДААР

Хүснэгт 6

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2024 он		2025 он		Өсөлт бууралтын % 2025.I/2024.I
			3 дугаар сар	I улирал	3 дугаар сар	I улирал	
1	Нийт ачаа эргэлт	тн.км	1,118,816,565.6	2,909,304,483.1	964,739,733.0	2,969,088,122.0	2.1%
2	Алтанбулаг	тн.км	512,515.9	1,248,588.4	367,632.0	1,175,507.0	-5.9%
3	Бичигт	тн.км	12,660,080.0	38,412,480.0	37,969,600.0	141,887,760.0	269.4%
4	Баянхошуу	тн.км	26,212,480.0	81,055,744.0	23,830,400.0	69,784,320.0	-13.9%
5	Бургастай	тн.км	4,243,040.0	11,179,680.0	0.0	2,379,360.0	-78.7%
6	Гашуунсухайт	тн.км	802,132,843.0	2,204,970,256.0	680,149,100.0	2,178,156,350.0	-1.2%
7	Замын-Үүд	тн.км	1,694,266.0	3,875,546.5	1,504,391.0	4,134,494.0	6.7%
8	Цагаан нуур	тн.км	1,526,030.0	4,220,800.0	270,500.0	1,080,800.0	-74.4%
9	Ханги	тн.км	14,927,616.0	35,400,226.0	7,029,520.0	25,804,220.0	-27.1%
10	Шивээ хүрэн	тн.км	147,261,985.0	291,807,360.0	141,492,910.0	303,616,690.0	4.0%
11	Хавирга	тн.км	273,444.7	317,832.3	298,080.0	761,921.0	139.7%
12	Булган	тн.км	107,113,650.0	236,094,250.0	71,763,650.0	239,936,200.0	1.6%
13	Боршоо	тн.км	258,615.0	721,720.0	63,950.0	370,500.0	-48.7%


2025 оны нэгдүгээр улирлын байдлаар автотээврийн ачаа эргэлт нийт 2.9 тэрбум тонн км ачаа болсон нь өмнөх оны мөн үеэс 2.1%-аар өссөн байна. Үүнээс Гашуунсухайт боомтоор ачаа эргэлт хамгийн их байгаа бөгөөд 2.2 тэрбум тонн км байгаа нь нийт ачаа эргэлтийн 73.4%-ийг дангаар бүрдүүлж байна. Харин хамгийн их өсөлттэй байгаа боомт нь Бичигт буюу тус боомтоор 141.9 сая тонн км ачаа эргэлт хийсэн нь өмнөх оны I-р улирлаас 3 дахин өссөн байна. /Хүснэгт 6/

2.2. АВТОТЭЭВРИЙН ЗОРЧИГЧ

Хүснэгт 7

Зорчигч тээвэр	Хэмжих нэгж	2024 он		2025 он		Өсөлт бууралтын % 2025.I/2024.I
		3 дугаар сар	I улирал	3 дугаар сар	I улирал	
Нийт зорчигч тээвэр	хүн	12,922,564.0	33,883,363.0	13,850,887.0	36,649,291.0	8.2%
Олон улсад зорчигчид	хүн	52,623.0	160,194.0	26,304.0	116,360.0	-27.4%
Хот хоорондын зорчигч	хүн	100,243.0	357,451.0	124,256.0	378,738.0	6.0%
Хот доторх нийтийн тээврээр зорчигч	хүн	12,769,698.0	33,365,718.0	13,700,327.0	36,154,193.0	8.4%
Зорчигч эргэлт	сая хүн.км	168.6	512.4	185.4	541.3	5.6%

Зураг 13. Зорчигч тээвэр



Автотээврээр 2025 оны 3 дугаар сард 13.9 сая зорчигч зорчсон нь өмнөх оны 3 дугаар сараас 7.2%-аар өссөн байна. Үүнээс олон улсад 26.3 мянган зорчигч (-50%), орон нутагт 124.3 мянган зорчигч (+24%), нийслэлийн нийтийн тээврийн хэрэгслээр 13.7 сая зорчигч (+7.3%) тус тус зорчсон байна.

Нэгдүгээр улиралд нийт 36.6 сая зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 8.2%-аар өссөн. Үүнээс нийслэлийн нийтийн тээврээр 36.2 сая зорчигч (+8.4%), орон нутагт 378.7 мянган зорчигч (+6%), олон улсад 116.4 мянган зорчигч (-27.4%) зорчжээ.

Автотээврийн зорчигчийн 98.1%-ийг нийслэлийн нийтийн тээвэр, 1.4%-ийг хот хооронд буюу орон нутгийн зорчигч, 0.5%-ийг олон улсын зорчигчид эзэлж байна. /Зураг 13/

№	Аймгийн нэр	№	Сум дүүргийн нэр	Тээвэрлэлтийн зай	Тээврийн хэрэгслийн төрөл	Өссөн дүнгээр					Зорчигч эргэлт /хүн+км/
						Суудал ашиглалт	Рейс	Зорчигч			
								УБ-аас гарсан	ОН-аас ирсэн	Бүгд	
0	1	2	3	4	5	16.0	17	18	19	20	21
1	Архангай	1	Цэцэрлэг	560	том оврын	50.3	10	254	181	508	284480
		2	Эрдэнэбулган	498	том оврын	60.5	279	7827	7316	15654	7795692
		3	Тариат	647	том оврын	20.5	13	139	103	278	179866
		4	Жаргалант	571	том оврын	68.2	12.5	383	374	766	437386
		5	Эрдэнэмандал	511	том оврын	45.1	15.5	362	232	724	369964
2	Баян-Өлгий	6	Өлгий-сум	1709	том оврын	71.2	175	4257	7037	8514	14550426
3	Баянхонгор	7	Баянхонгор	640	том оврын	78.1	341.5	11071	12344	22142	14170880
4	Булган	8	Булган	438	том оврын	58.0	90.5	2244	2499	4488	1965744
5	Говь-Алтай	9	Есөнбулаг	1037	том оврын	74.7	195.5	6238	6834	12476	12937612
		10	Бигэр	1247	том оврын						
6	Дархан-Уул	11	Дархан	219	том оврын	53.4	716	18731	15074	37462	8204178
		12		219	суудлын	94.3	346	1254	1354	2508	549252
		13	Шарын гол	279	том оврын						
7	Дорнод	14	Баян-Уул	600	том оврын	58.0	12	266	343	609	365400
		15	Хэрлэн сум	658	том оврын	88.0	287	9253	9735	18988	12494104
8	Дундговь	16	Эрдэнэдалай	375	том оврын						
		17	Сайхан Овоо	505	том оврын						
9	Завхан	18	Улиастай	1023	том оврын	77.2	186.5	6048	6863	12911	13207953
		19	Тосонцэнгэл	838	том оврын	75.3	95.5	2977	3444	6421	5380798
		20	Тэс	1114	том оврын	66.6	24	757	716	1473	1640922
		21	Отгон	1037	том оврын	77.3	14	496	482	978	1014186
10	Орхон	22	Баян-Өндөр	378	том оврын	64.1	547	16012	15035	31047	11735766
		23		378	суудлын	82.5	491.5	1325	1884	3209	1213002
11	Өвөрхангай	24	Арвайхээр	431	том оврын	52.1	347.5	7656	8205	15861	6836091
		25	Хужирт	384	том оврын	37.4	56.5	1265	660	1925	739200
		26	Хархорин	365	том оврын	48.9	90	1829	2146	3975	1450875
		27	Сант	409	том оврын	54.6	12.5	446	188	634	259306
		28	Бат-Өлзий	433	том оврын	59.7	54	1340	1593	2933	1269989
12	Өмнөговь	29	Даланзадгад	575	том оврын	49.2	85.5	1886	2002	3888	2235600
		30	Цогтцэций	544	том оврын	73.0	352	12348	10689	23037	12532128
		31	Цагаанхад	933	том оврын	68.2	88.5	3026	2315	5341	4983153
13	Дорноговь	32	Сайншанд	450	том оврын	62.0	92	2857	2207	5064	2278800
		33	Замын-Үүд	660	том оврын						
14	Сүхбаатар	34	Баруун-Урт	565	том оврын	67.0	178	5194	5352	10546	5958490
		35	Дарьганга	710	том оврын	48.0	9	170	213	383	271930
		36	Эрдэнэцагаан	768	том оврын	56.0	26	678	584	1262	969216
15	Сэлэнгэ	37	Сүхбаатар	343	том оврын	78.3	92	3452	2926	6378	2187654
16	Төв	38	Борнуур	102	дунд оврын						
		39	Зуунмод	43	дунд оврын	63.9	940	6634	6742	13376	575168
		40	Батсүмбэр	79	дунд оврын						
		41	Жаргалант	128	дунд оврын	31.6	79	624	342	966	123648
17	Ховд	42	Хо.Жаргалант	1488	том оврын	61.0	297	6906	9045	15951	23735088
		43	Хо.Булган	1720	том оврын	57.1	53.5	1187	1601	2788	4795360
18	Хэнтий	44	Өндөрхаан	338	том оврын	65.0	181	5111	5390	10501	3549338
		45	Хэ.Батноров	443	том оврын						
19	Хөвсгөл	46	Мөрөн	788	том оврын	72.4	580	17297	20350	37647	29665836
		47	Галт	920	дунд оврын	87.9	8.5	276	301	577	530840
20	Увс	48	Улаангом	1382	том оврын	70.8	348	9291	11817	21108	29171256
		49	Ув.Өмнөговь	1367	том оврын	69.4	12	352	428	780	1066260
		50	Өндөрхангай	1165	том оврын	68.4	11	284	425	709	825985
		51	Зүүнговь	1280	том оврын	83.8	13	407	572	979	1253120
21	ОХУ	52	Улан-Үд	600	том оврын	27.4	114.5	1376	1328	2704	1622400
22	БНХАУ	53	Эрээн	676	том оврын	55.0	144	3994	2913	6907	4669132
Нийт дүн				35,918			8117	185,780	192,184	377,376	252053474

2025 оны 3 дугаар сард орон нутагт автотээвэрээр нийт 124.3 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны 3 дугаар сараас 24%-аар өссөн байна. Нэгдүгээр улирлын байдлаар 378.7 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 6%-аар өссөн байна. Нэгдүгээр улирлын байдлаар Дархан-Уул аймаг руу 39.9 мянга, Хөвсгөл аймгийн Мөрөн чиглэл рүү 37.6 мянган зорчигч хамгийн их зорчсон байна. Дэлгэрэнгүй мэдээллийг дээрх хүснэгтэд харуулав. ⁴


⁴ “Автотээврийн Үндэсний төв” ТӨҮГ-ийн статистикийн мэдээ

2.3. АВТО ЗАМЫН БООМТУУДААР НЭВТЭРСЭН АЧААТАЙ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН БҮРТГЭЛ

Хүснэгт 9

Авто замын боомтуудаар нэвтэрсэн ачаатай тээврийн хэрэгслийн тоо	2024 он		2025 он		Өсөлт бууралтын % 2025.I/2024.I
	3 дугаар сар	I улирал	3 дугаар сар	I улирал	
	81,299	189,717	61,335.0	195,901.0	3.3%
Орсон тээврийн хэрэгсэл	8,926	20,886	10,286.0	27,827.0	33.2%
БНХАУ-аас	6,796	15,248	9,398.0	23,261.0	52.6%
Бичигт	0.0	0	0.0	0.0	-
Баянхошуу	0.0	0	1.0	1.0	-
Булган	0.0	0	0.0	0.0	-
Бургастай	0.0	0	0.0	0.0	-
Гашуунсухайт	174.0	539	577.0	1,074.0	99.3%
Шивээхүрэн	244.0	460	149.0	342.0	-25.7%
Замын-Үүд	6,290.0	14,023	8,628.0	21,656.0	54.4%
Ханги	40.0	140	23.0	72.0	-48.6%
Хавирга	48.0	86	20.0	116.0	34.9%
ОХУ-аас	2,130	5,638	888.0	4,566.0	-19.0%
Алтанбулаг	1,109.0	2,673	833.0	2,550.0	-4.6%
Боршоо	218.0	620	55.0	331.0	-46.6%
Цагааннуур	803.0	2,345	0.0	1,685.0	-28.1%
Гарсан тээврийн хэрэгсэл	72,373	168,831	51,049.0	168,074.0	-0.4%
БНХАУ-руу	69,851	162,600	50,256.0	149,648.0	-8.0%
Бичигт	2,141.0	6,537	4,704.0	16,832.0	157.5%
Баянхошуу	1,175.0	3,621	1,049.0	3,532.0	-2.5%
Булган	4,199.0	9,246	2,886.0	9,697.0	4.9%
Бургастай	1,634.0	4,484	0.0	491.0	-89.0%
Гашуунсухайт	33,150.0	75,664	23,253.0	73,873.0	-2.4%
Шивээхүрэн	17,703.0	38,533	14,979.0	32,888.0	-14.6%
Замын-Үүд	1,389.0	3,465	675.0	2,436.0	-29.7%
Ханги	8,349.0	20,939	2,602.0	9,642.0	-54.0%
Хавирга	111.0	111	108.0	257.0	131.5%
Сүмбэр	0.0	0	0.0	0.0	-
ОХУ-руу	2,522	6,231	793.0	18,426.0	195.7%
Алтанбулаг	915.0	2,397	742.0	16,338.0	581.6%
Боршоо	212.0	614	51.0	315.0	-48.7%
Цагааннуур	1,395.0	3,220	0.0	1,773.0	-44.9%

Зураг 14. Хилээр нэвтэрсэн тээврийн хэрэгсэл



Монгол Улсын авто замын боомтуудаар 2025 оны 3 дугаар сард нийт 61.3 мянган ачаатай тээврийн хэрэгсэл нэвтэрсэн нь өмнөх оны 3 дугаар сартай харьцуулахад 24.6%-аар буурчээ. Үүнээс 10.3 мянган тээврийн хэрэгсэл орсон нь өмнөх оны 3 дугаар сараас 15.2%-аар өссөн бол 51 мянган тээврийн хэрэгсэл гарсан нь өмнөх оны 3 дугаар сартай харьцуулахад 29.5%-аар буурсан үзүүлэлттэй байна. /Хүснэгт 9/

Оны эхнээс өссөн дүнгээр буюу нэгдүгээр улиралд нийт 195.9 мянган ачаатай тээврийн хэрэгсэл нэвтэрсэн нь өмнөх оны мөн үеэс 3.3%-аар өссөн байна. Үүнээс орсон ачаатай тээврийн хэрэгсэл 27.8 мянга болж өмнөх оны мөн үеэс 33.2%-аар өссөн бол гарсан тээврийн хэрэгсэл 168.1 мянга болж өмнөх оны мөн үеэс 0.4%-аар буурсан үзүүлэлттэй байна. /Зураг 14/

БҮЛЭГ 3. ТӨМӨР ЗАМЫН САЛБАР

3.1. ТӨМӨР ЗАМЫН АЧАА

Төмөр замын тээврээр 2025 оны I улиралд нийт 10.3 сая тонн ачаа тээвэрлэж өмнөх оны нэгдүгээр улиралтай харьцуулахад 5.5%-аар буурлаа.


Хүснэгт 10

Үзүүлэлт	Хэмжиг нэгж	2024 он		2025 он		Өсөлт бууралтын % 2025.I/2024.I
		3 дугаар сар	I улирал	3 дугаар сар	I улирал	
Ачаа тээвэрлэлт	мян.тн	3,905.6	10,900.3	3,403.0	10,301.3	-5.5%
"Улаанбаатар төмөр зам" ХНН	мян.тн	2,924.8	8,563.9	2,730.0	8,298.3	-3.1%
"Монголын төмөр зам" ТӨХК	мян.тн	229.2	512.5	184.8	487.3	-4.9%
"Тавантолгой төмөр зам" ХХК	мян.тн	348.7	723.2	121.0	442.9	-38.8%
"Монголиантранс Логистик" ХХК	мян.тн	303.5	921.8	330.2	937.5	1.7%
"Монголиантранс Лайн" ХХК	мян.тн	99.5	179.0	36.9	135.3	-24.4%
Дотоодын ачаа	мян.тн	2,166.0	5,875.4	1,710.9	5,251.2	-10.6%
үүнээс "Улаанбаатар төмөр зам" ХНН	мян.тн	1,185.2	3,539.0	1,038.0	3,248.2	-8.2%
"Монголын төмөр зам" ТӨХК	мян.тн	229.2	512.5	184.8	487.3	-4.9%
"Тавантолгой төмөр зам" ХХК	мян.тн	348.7	723.2	121.0	442.9	-38.8%
"Монголиантранс Логистик" ХХК	мян.тн	303.5	921.8	330.2	937.3	1.7%
"Монголиантранс Лайн" ХХК	мян.тн	99.5	179.0	36.9	135.3	-24.4%
Импорт ачаа	мян.тн	329.4	1,010.0	266.3	887.1	-12.2%
БНХАУ-аас	мян.тн	87.5	282.3	75.1	207.7	-26.4%
ОХУ-руу	мян.тн	242.0	727.7	191.2	679.4	-6.6%
Экспорт ачаа	мян.тн	991.6	2,741.7	907.0	2,773.1	1.1%
БНХАУ-руу	мян.тн	977.7	2,703.0	893.7	2,734.5	1.2%
ОХУ-руу	мян.тн	13.9	38.8	13.3	38.8	-0.1%
Дамжин өнгөрөх ачаа	мян.тн	418.5	1,273.2	518.7	1,389.9	9.2%
БНХАУ-аас ОХУ-руу	мян.тн	129.2	376.4	134.1	409.3	8.8%
ОХУ-аас БНХАУ-руу	мян.тн	289.3	896.8	384.6	980.6	9.3%
Ачаа эргэлт	сая.тн-км	1,862.6	5,249.4	1,807.6	5,202.0	-0.9%


Төмөр замын тээврээр 2025 оны 3 дугаар сард нийт 3.4 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны 3 дугаар сартай харьцуулахад 12.9%-аар буурлаа. Үүнээс дотоодын ачаа 1.7 сая тонн болж өмнөх оны 3 дугаар сараас 21%-аар, импортын ачаа 266.3 мянган тонн болж 19.2%-аар, экспортын ачаа 907 мянган тонн болж 8.5%-аар тус тус буурсан бол дамжин өнгөрсөн ачаа 518.7 мянган тонн болж 23.9%-аар өссөн үзүүлэлттэй байна. /Хүснэгт 11/

Нэгдүгээр улиралд нийт 10.3 сая тонн ачаа тээвэрлэж өмнөх оны нэгдүгээр улиралтай харьцуулахад 5.5%-аар, дотоодын ачаа 5.3 сая тонн болж 10.6%-аар, импортын ачаа 887.1 мянган тонн болж 12.2%-аар тус тус буурсан бол дамжин өнгөрсөн ачаа 1.4 сая тонн болж 9.2%-аар экспортын ачаа 2.8 сая тонн 1.1%-аар тус тус өссөн байна. /Зураг 15/

Зураг 15. Төмөр замын ачаа, мян.тн




Зураг 16. Төмөр замын ачаа, байгууллагуудын эзлэх хувь




Нэгдүгээр улирлын байдлаарх нийт ачаа тээврийн 8.3 сая тонн буюу 81%-ийг "Улаанбаатар төмөр зам" ХНН, 937.3 мянган тонн буюу 9%-ийн ачааг "Монголиантранс Логистик" ХХК, 487.3 мянган тонн буюу 5%-ийг "Монголын төмөр зам" ТӨХК, 442.9 мянган тонн буюу 4%-ийн ачааг "Тавантолгой төмөр зам" ХХК, 135.3 мянган тонн ачаа буюу нийт ачааны 1%-ийг "Монголиантранс Лайн" ХХК-иуд тус тус тээвэрлэсэн байна. /Зураг 16/

Зураг 17. Төмөр замын ачаа тээврийн төрөл



Ачаа тээвэрлэлтийн төрлөөр авч үзвэл нийт ачаа тээврийн 5.3 сая тонн буюу 51%-ийг дотоодын ачаа, 2.8 сая тонн буюу 27%-ийг экспортын ачаа, 1.4 сая тонн буюу 13%-ийг дамжин өнгөрсөн ачаа, 0.9 сая тонн буюу 9%-ийг импортын ачаа тээвэр эзэлж байна. /Зураг 17/


Зураг 18. Дотоодын ачаа, байгууллагуудын эзлэх хувь




Дотоодод тээвэрлэсэн 5.3 сая тонн ачааны 3.2 сая тонн ачаа буюу 62%-ийг "Улаанбаатар төмөр зам" ХНН, 937.3 мянган тонн ачаа буюу 18%-ийг "Монголиантранс Логистик" ХХК, 487.3 мянган тонн буюу 9%-ийг "Монголын төмөр зам" ТӨХК, 442.9 мянган тонн ачаа буюу 8%-ийг "Тавантолгой төмөр зам" ХХК, 135.3 мянган тонн буюу 3%-ийг "Монголиантранс Лайн" ХХК тус тус эзэлж байна. /Зураг 18/

2025 оны эхний 3 сарын байдлаар байгууллагуудын ачаа тээврийн хоногийн дундажийг тооцоход "УБТЗ" ХНН хоногт дунджаар 92.2 мянган тонн, "МТЛогистик" ХХК нь 10.4 мянган тонн, "МТЗ" ТӨХК нь 5.4 мянган тонн, "ТТЗ" ХХК нь 4.9 мянган тонн, "МТЛайн" ХХК нь 1.5 мянган тонн ачаа тээвэрлэж байна. /Зураг 19/

Зураг 19. Хоногт тээвэрлэх ачааны дундаж жин, мян.тн, байгууллагаар




Зураг 20. Төмөр замаар тээвэрлэсэн ачааны хэмжээ, өдрөөр, 2025.01.01-2025.03.31



Төмөр замын байгууллагуудаар өдөр бүр тээвэрлэсэн ачааны хэмжээг төрлөөр нь Зам, тээврийн салбарын нэгдсэн платформоос оруулав. 2025 оны эхний 3 сарын байдлаар өдөрт дундажаар орон нутгийн ачаа 51.2 мянга, экспортын ачаа 28.5 мянга, дамжин өнгөрсөн ачаа 14.9 мянга, импортод дундажаар 11.2 мянган ачаа тээвэрлэсэн байна. /Зураг 20/

Зураг 21. Төмөр замын байгууллагуудын ачаа тээвэр, хоногоор



2025 оны нэгдүгээр улирал буюу 2025.01.01-ний өдрөөс 2025.03.31-ний өдрийг хүртэлх төмөр замын тээврийн байгууллагуудын тээвэрлэсэн ачааны хоног бүрийн мэдээг графикаар харуулав. 1 дүгээр улиралд УБТЗ 2025.01.03-ны өдөр 115.3 мянган тонн хамгийн их ачаа тээсэн бол 2025.03.29-ний өдөр 40.7 мянган тонн хамгийн бага ачаа тээсэн байна. “МТЛожистик” ХХК нь 2025.02.05-ны өдөр 18.9 мянган тонн хамгийн их ачаа тээсэн бол 2025.03.31-ний өдөр тээвэрлэлт хийгээгүй байна. “ТТЗ” ХХК нь 2025.01.17-ны өдөр 17.2 мянган тонн хамгийн их ачаа байна. “МТЗ” ТӨХК нь 2025.01.19-ний өдөр 14.6 мянган тонн хамгийн их ачаа тээсэн бол 2025.03.23-ны өдөр 265.4 тонн хамгийн бага ачаа тээсэн байна. “МТЛайн” ХХК 2025.01.13-ны өдөр хамгийн их 11.3 мянган тонн ачаа тээсэн байна. /Зураг 21/


3.2. ТӨМӨР ЗАМЫН ЗОРЧИГЧ

Төмөр замаар 2025 оны I улиралд 7.2 мянган зорчигч олон улсад тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 27.2%-аар өссөн байна.

Хүснэгт 11

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2024 он		2025 он		Өсөлт бууралтын % 2025.I/2024.I
		3 дугаар сар	I улирал	3 дугаар сар	I улирал	
Зорчигч тээвэрлэлт	мян.хүн	141.79	435.2	138.0	399.2	-8.3%
Олон улс	мян.хүн	1.94	5.6	2.1	7.2	27.2%
Орон нутаг	мян.хүн	139.9	429.6	135.9	392.1	-8.7%
Зорчигч эргэлт	сая хүн.км	57.63	172.5	56.5	167.4	-3.0%


2025 оны 3 дугаар сард нийт 138 мянган зорчигч төмөр замаар зорчиж өмнөх оны 3 дугаар сартай харьцуулахад 2.7%-аар буурсан. Үүнээс олон улсад 2.1 мянган зорчигч зорчсон нь 6.7%-аар өссөн бол орон нутагт 135.9 мянган зорчигч зорчсон нь 2.8%-аар буурчээ.



Нэгдүгээр улиралд нийт 399.2 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 8.3%-аар буурсан байна. Үүнээс олон улсад 7.2 мянган зорчигч зорчсон нь 27.2%-аар өссөн бол харин орон нутагт 392.1 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 8.7%-аар буурсан байна.

Зорчигч тээвэрлэлт буурсан гол шалтгаан нь төмөр замын зорчигч тээврийн 98%-ийг эзэлж буй орон нутагт зорчих зорчигчдын тоо тогтмол буурч байгаатай холбоотой бөгөөд зорчигчид орон нутагт вагоноор зорчихоос илүү автомашинаар зорчих нь нэмэгдсэн байна. /Зураг 22/

Зураг 23. Төмөр замын зорчигч, хоногоор



2025.01.01-2025.03.31-ний өдрүүдэд Улаанбаатар төмөр замаар зорчсон зорчигчийн тоог хоногоор нь Зам, тээврийн салбарын нэгдсэн платформуус нэгтгэн гаргав. 2025 оны эхний 3 сарын байдлаар төмөр замаар хоногт дундажаар 4.4 мянган зорчигч зорчиж байна. /Зураг 23/


БҮЛЭГ 4. ИРГЭНИЙ НИСЭХИЙН САЛБАР

4.1 АГААРЫН ТЭЭВРИЙН АЧАА

Хүснэгт 12

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2024 он		2025 он		Өсөлт бууралтын % 2025.I/2024.I
			3 дугаар сар	I улирал	3 дугаар сар	I улирал	
1	Нийт ачаа, шуудан тээвэр	тн	773.9	2,191.8	704.0	2,026.0	-7.6%
2	олон улсад	тн	772.4	2,186.3	699.0	2,016.6	-7.8%
3	орон нутагт	тн	1.5	5.5	5.0	9.4	70.9%
4	Нийт ачаа	тн	753.8	2,133.0	688.0	1,974.4	-7.4%
5	олон улсад	тн	752.3	2,127.6	683.0	1,965.0	-7.6%
6	орон нутагт	тн	1.5	5.5	5.0	9.4	71.2%
7	Нийт шуудан	тн	20.1	58.8	16.0	51.6	-12.2%
8	олон улсад	тн	20.1	58.7	16.0	51.6	-12.1%
9	орон нутагт	тн	0.0	0.0	0.0	0.0	-
10	Ачаа эргэлт	мян.тн-км	2,975.1	7,312.1	3,766.74	9,297.2	27.1%
11	олон улсад	мян.тн-км	2,974.2	7,309.1	3,765.4	9,293.6	27.2%
12	орон нутагт	мян.тн-км	0.9	3.0	1.3	3.6	22.6%

Зураг 24. Агаараар тээвэрлэсэн ачаа болон шуудан



Агаарын тээврээр 2025 оны 3 дугаар сард 704 тонн ачаа, шуудан тээвэрлэсэн нь өмнөх оны 3 дугаар сартай харьцуулахад 9%-аар буурсан. Үүнээс ачаа 688 тонн болж 8.7%-аар, шуудан 16 тонн болж 20.4%-аар тус тус буурсан үзүүлэлттэй байна.


Харин улирлын дүнгээр 2,026.0 тонн ачаа болон шуудан тээвэрлэж өмнөх оны I улирлаас 7.6%-аар буурсан байна. Үүнээс ачаа 1,974.4 тонн тээвэрлэсэн нь 7.4%-аар, шуудан 51.6 тонн тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 12.2%-аар тус тус буурсан байна. /Зураг 24/

Нэгдүгээр улиралд олон улсад тээвэрлэсэн ачаа шуудан 2,016.6 тонн болсон нь өмнөх оны мөн үеэс 7.8%-аар буурсан бол орон нутагт тээвэрлэсэн ачаа шуудан 9.4 тонн болж өмнөх оны мөн үеэс 70.9%-аар өссөн байна. /Зураг 25/


Агаарын тээврээр тээвэрлэсэн нийт ачаа шуудангийн 99.5%-ийг олон улсад тээвэрлэсэн бол 0.5%-ийг орон нутагт тээвэрлэсэн байна. Мөн нийт ачаа шуудангийн 97.4%-ийг ачаа эзэлж байгаа бол 2.6%-ийг шуудан эзэлж байна.

Ачаа эргэлт 2025 оны нэгдүгээр улирлын байдлаар 9.3 сая тонн км болсон нь өмнөх оны мөн үеэс 27.1%-аар өсчээ.

Зураг 25. Олон улс, орон нутгийн ачаа, шуудан



Зураг 26. Нийт ачаа, шуудан тээвэр, тонн, сараар




4.2. АГААРЫН ТЭЭВРИЙН ЗОРЧИГЧ

Агаарын тээврээр 2025 оны нэгдүгээр улиралд нийт 479.3 мянган зорчигч тээвэрлэж өмнөх оны мөн үеэс 16.4%-аар өслөө.

Хүснэгт 13

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2024 он		2025 он		Өсөлт бууралтын % 2025.I/2024.I
		3 дугаар сар	I улирал	3 дугаар сар	I улирал	
Нийт зорчигч тээвэр	хүн	127,572	411,978	148,113	479,349	16.4%
Олон улсад	хүн	95,439	314,832	114,262	380,808	21.0%
Орон нутагт	хүн	32,133	97,146	33,851	98,541	1.4%
Зорчигч эргэлт	мян.хүн км	281,200.1	1,008,509.3	340,351.0	1,261,407.0	25.1%
Олон улсад	мян.хүн км	261,562.1	950,401.0	320,586.0	1,203,648.0	26.6%
Орон нутагт	мян.хүн км	19,637.9	58,108.3	19,765.0	57,759.0	-0.6%




2025 оны 3 дугаар сард агаарын тээврээр нийт 148.3 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны 3 дугаар сартай харьцуулахад 16.1%-аар өссөн. Үүнээс олон улсад 114.3 мянган зорчигч зорчиж 19.7%-аар, орон нутагт 33.9 мянган зорчигч зорчиж 5.3%-аар тус тус өссөн байна.

Улирлын дүнгээр нийт 479.3 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны нэгдүгээр улирлаас 16.4%-аар өссөн бол үүнээс олон улсад 380.8 мянган зорчигч зорчсон нь 21%-аар, орон нутагт 98.5 мянган зорчигч зорчсон нь 1.4%-аар тус тус нэмэгдсэн байна. /Хүснэгт 14/

Сар бүрийн зорчигч тээврийн үзүүлэлтийг харахад 6 дугаар сараас 9 дүгээр сар хүртэл ачаалал нэмэгдсэн нь зуны улиралд аялал жуулчлалын зорилгоор зорчих иргэдийн тоо нэмэгдсэнтэй холбоотой байна./Зураг 28 /

Зураг 28. Агаарын тээврийн зорчигчдын тоо, сараар




Зорчигч эргэлт 2025 оны I дүгээр улиралд 1,261.4 сая хүн км болж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 25.1%-аар өссөн. Үүнээс олон улсын зорчигч эргэлт 1,203.6 сая хүн км болж 26.6%-аар өссөн бол орон нутгийн зорчигч эргэлт 57.8 сая хүн км болж 0.6%-аар буурсан байна.

4.2.1. АГААРЫН ТЭЭВРИЙН ОЛОН УЛСЫН ЗОРЧИГЧ

Хүснэгт 14

№	Үзүүлэлт	2024 он		2025 он		Өсөлт бууралтын % 2025.I/2024.I
		3 дугаар сар	I улирал	3 дугаар сар	I улирал	
1	Олон улсад	95,439	314,832	114,262	380,808	21.0%
2	чиглэл Сөүл	31,570	100,192	35,862	112,063	11.8%
3	Бээжин	18,756	50,786	20,866	58,174	14.5%
4	Токио	9,272	23,982	10,562	28,958	20.7%
5	Истанбул	9,672	28,954	9,317	28,021	-3.2%
6	ХонКонг	6,073	19,210	7,771	24,906	29.7%
7	Фукуок	1,489	17,817	1,376	18,831	5.7%
8	Франкфурт	4,554	13,594	5,177	14,906	9.7%
9	Хөх хот	2,189	7,558	4,321	14,244	88.5%
10	Бангкок	1,474	10,927	2,425	13,558	24.1%
11	Хо Ши Мин	0	1,891	2,082	11,068	485.3%
12	Санья/Хайнань	1,036	4,732	2,463	9,583	102.5%
13	Пукет	378	7,900	1,065	9,405	19.1%
14	Бусан	2,027	6,511	2,608	7,455	14.5%
15	Хайкоу/Хайнань	919	2,361	681	3,892	64.8%
16	Эрхүү	1,305	3,332	1,345	3,731	12.0%
17	Алмата	1,026	3,549	1,588	3,292	-7.2%
18	Бусад	3,699	11,536	4,753	18,721	62.3%


Зураг 29. Олон улсын зорчигч тээвэр, чиглэлээр



2025 оны нэгдүгээр улиралд олон улсад нийт 380.8 мянган зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 21%-аар өссөн. Сөүл чиглэлд 112.1 мянган зорчигч (+11.8%), Бээжин хотруу 58.2 мянган зорчигч (+14.5%), Токио чиглэлд 28.9 мянган зорчигч (+20.7%), Истанбул хотруу 28 мянган зорчигч (-3.2%), ХонгКонг чиглэлрүү 24.9 мянган зорчигч (+29.7%), Фукуок чиглэлд 18.8 мянган зорчигч (+5.7%) тус тус тээвэрлэсэн байна. Үүнээс Хо Ши Мин, Хөх хот, Хайнань чиглэлд зорчигчийн тоо эрс нэмэгдсэн нь гадагшаа чиглэсэн аялал жуулчлалын үйл ажиллагаатай холбоотой байна. /Зураг 29/

Олон улсад зорчсон зорчигчдын 51% буюу 194.9 мянган зорчигч үндэсний агаарын тээвэрлэгч “МИАТ” ТӨХК нислэгээр ниссэн бол “Корейн айр”-ийн нислэгээр 34.3 мянга, “Айрчайна”-ийн нислэгээр 33 мянга, “Хүннү Эйр” ХХК-ийн нислэгээр 34 мянга, “Туркиш эйрлайнс” ХХК-ын нислэгээр 15.9 мянга, “Аэро Монголиа” ХХК-ийн нислэгээр 33.9 мянга, Жэжү айр нислэгээр 9.1 мянга, Ашиана эйрлайнс нислэгээр 9.7 мянга, Вьетжет айр нислэгээр 7.8 мянга, Жунияо айр нислэгээр 3.8 мянга, Ираеро нислэгээр 3.5 мянган зорчигч, Красавиа нислэгээр 590, захиалгат нислэгээр 41 зорчигч зорчсон байна. /Зураг 30/

Зураг 30. Олон улсын зорчигч, агаарын тээвэрлэгч байгууллагуудын эзлэх хувь




4.2.2. АГААРЫН ТЭЭВРИЙН ОРОН НУТГИЙН ЗОРЧИГЧ

Хүснэгт 15

№	Үзүүлэлт	2024 он		2025 он		Өсөлт бууралтын % 2025.I/2024.I
		3 дугаар сар	I улирал	3 дугаар сар	I улирал	
1	Орон нутагт зорчигч тээвэр	32,133	97,146	33,851	98,541	1.4%
2	чиглэл Ховд	988	2,724	1,445	3,906	43.4%
3	Улаангом	280	586	355	1,405	139.8%
4	Алтай	557	1,767	446	1,526	-13.6%
5	Оюутолгой	28,169	85,640	29,566	85,394	-0.3%
6	Оюутолгой/Даланзадгад	36	410		0	-100.0%
7	Мөрөн	480	754	525	1,551	105.7%
8	Өлгий	837	2,025	1,117	3,316	63.8%
9	Улиастай	401	1,327	392	1,438	8.4%
10	Даланзадгад	272	770	0	0	-100.0%
11	Мөрөн/Улаангом	113	909	0	0	-100.0%
12	Бусад	0	178	5	5	-97.2%


Зураг 31. Орон нутгийн зорчигч, чиглэлээр



2025 оны 3 дугаар сард орон нутагт нийт 33.9 мянган зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оны 3 дугаар сартай харьцуулахад 5.3%-аар өссөн байна.

Оны эхнээс өссөн дүнгээр буюу нэгдүгээр улиралд орон нутагт нийт 98.5 мянган зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 1.4%-аар өссөн бол Мөрөн, Улаангом, Өлгий чиглэлд зорчигчийн тоо нэмэгдсэн байна. /Хүснэгт 15/

Зураг 32. Орон нутгийн зорчигч, агаарын тээвэрлэгч байгууллагуудын эзлэх хувь



2025 оны нэгдүгээр улиралд агаарын тээврээр орон нутаг зорчигчдын 66% буюу 65.3 мянган зорчигч “МИАТ” ТӨХК-ийн нислэгээр, 23% буюу 22.4 мянган зорчигч “Аэро Монголиа” ХХК-ийн нислэгээр, 11% буюу 10.8 мянган зорчигч “Хүннү Эйр” ХХК-ийн нислэгээр тус тус зорчсон байна. Орон нутаг “МИАТ” ХХК-ийн зорчигч 9%-аар, “Аэро Монголиа” ХХК зорчигч 16.9%-аар тус тус нэмэгдсэн бол “Хүннү эйр” ХХК-аар зорчсон зорчигчийн тоо 40%-аар буурсан үзүүлэлттэй байна. /Зураг 32/

4.3. НИСЛЭГ ГҮЙЦЭТГЭЛ

Үзүүлэлт	2024 он		2025 он		Хүснэгт 16 Өсөлт, бууралтын % 2025.I/2024.I
	3 дугаар сар	I улирал	3 дугаар сар	I улирал	
Нийт нислэгийн тоо	6,474	18,988	7,951	23,105	21.7%
Олон улсын өнгөрөлтийн нислэг	5,080	14,772	6,332	18,251	23.6%
Хөөрөлт, буулт	1,394	4,216	1,619	4,854	15.1%
Олон улсын хөөрөлт, буулт	795	2,432	877	2,800	15.1%
Орон нутгийн хөөрөлт, буулт	599	1,784	742	2,054	15.1%

2025 оны 3 дугаар сард нийт нислэгийн тоо 7,951 болж өмнөх оны 3 дугаар сартай харьцуулахад 22.8%-аар, олон улсын өнгөрөлтийн нислэгийн тоо 6,332 болж 24.6%-аар тус тус өссөн байна. Олон улсын хөөрөлт, буулт 877 болж 10.3%-аар, орон нутгийн хөөрөлт, буултын тоо 742 болж 23.9%-аар тус тус өссөн байна.

2025 оны нэгдүгээр улиралд нийт нислэгийн тоо 23,105 болж өмнөх оны мөн үеэс 21.7%-аар, олон улсын өнгөрөлтийн нислэгийн тоо 18,251 болж өмнөх оны мөн үеэс 23.6%-аар, олон улсын хөөрөлт, буултын тоо 2,800, орон нутгийн хөөрөлт, буултын тоо 1783 болж өмнөх оны мөн үеэс 15.1%-аар тус тус өссөн үзүүлэлттэй байна. /Зураг 33/

Зураг 33. Нислэг гүйцэтгэлийн мэдээ, сараар

